



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/793

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60:1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI дугаар хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эрүүл Булган” хөтөлбөр, “Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд Хялганат тосгоны эрүүл мэндийн төвийн шүдний кабинетэд шаардлагатай шүдний рентген аппаратыг “Сүкэ Холдинг” ХХК-аас 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгөөр гэрээ шууд байгуулах эрхийг Эрүүл мэндийн газрын дарга (П.Оюунцэцэг)-д олгосугай

2. Гэрээнд заагдсан шүдний рентген аппаратыг техникийн тодорхойлолтын дагуу тогтоосон хугацаанд хүлээлгэн өгөхийг “Сүкэ Холдинг” ХХК (У.Батсүх)-д үүрэг болгосугай.

3. Хялганат тосгоны эрүүл мэндийн төвийн шүдний кабинетэд шаардлагатай шүдний рентген аппаратын санхүүжилтийг “Эрүүл Булган” хөтөлбөрийн батлагдсан хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Булган Аймаг 2025 оны 12 сарын 18 өдөр

6325011194